

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД
ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ

2025 оны 02 сарын 13-ны өдөр

Дугаар: БА-049/2025

Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын нийслэлийн Налайх дүүргийн 7 дугаар хороонд баригдсан дунд төвөгшилтэй ангиллын зорьтой 9 давхар 1 блок, 10 (арван) автомашины дулаан зогсоолтой, 54 (тавин дөрөв) айлын хүчин чадалтай орон сууцны зориулалттай барилга байгууламжид Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/503 дугаар захирамжийн шийдвэрээр байгуулагдсан 15 гишүүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

2.1. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний 2024/12/31 огноо, БА32024/0959 №0001954 дугаар;

2.2. Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар: ШХ-01-01/22;

2.3. Захиалагч: Дөлгөөн дөл ХХК оноосон нэр, 2911002091 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 2542609 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 2 дугаар хороо, Их найман шарга голомт банкттай байр, 5 давхар 501 тоот, өөрийн байр, 99115635 холбоо барих утас, nalgartushig2006@gmail.com цахим хаяг;

2.4. Барилгын ажлын ерөнхий гүйцэтгэгч: Ус орчин ХХК оноосон нэр, 9011013120 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 2657694 регистрийн дугаар, БУ11-410/22 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 2 дугаар хороо, Их найман шарга голомт банкттай байр 5 давхар 501 тоот, өөрийн байр, 99115635 холбоо барих утас, nalgartushig2006@gmail.com цахим хаяг;

2.5. Барилгын туслан гүйцэтгэгч байгууллага: Эл Өү Ти ХХК оноосон нэр, 9011840651 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 6882943 регистрийн дугаар, БУ11-616/22 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 8 дугаар хороо, 3-р хороолол, Ард аюуш, Баянгол их дэлгүүр, 406 тоот, 80110282 холбоо барих утас,

ЭН И ТИ ЭЛ ХХК оноосон нэр, 291100421 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 4489985 регистрийн дугаар, 2187/22 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Налайх дүүрэг, 2 дугаар хороо, Даваажавын гудамж 38-р байр, 65 тоот, 88091224 холбоо барих утас,

Барилга байгууламжийг ашиглалтанд
оруулах комисс

СМҮК АДДРЕСС ХХК оноосон нэр, 9011845463 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 6947476 регистрийн дугаар, №12100707 ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 1 дүгээр хороо, толгойт 50-864 тоот, 95952302 холбоо барих утас,

Эрхэт наран ХХК оноосон нэр, 9011855215 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5376777 регистрийн дугаар, БУ16-1175/19 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо Континентал төв, 201 тоот, 70007014, 99997854 холбоо барих утас,

2.6. Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: Шувууны хайрга ХХК оноосон нэр, 9011087048 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5120349 регистрийн дугаар, 3Т11-506/18 зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, Жалханз хутагт Дамдинбазарын гудамж 47А-71 тоот, 99100722 холбоо барих утас,

2.7. Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага: Дөлгөөн дөл ХХК оноосон нэр, 2911002091 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 2542609 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 2 дугаар хороо, Их найман шарга голомт банкттай байр 5 давхар 501 тоот, өөрийн байр, 99115635 холбоо барих утас, nalgartushig2006@gmail.com цахим хаяг;

2.8. Барилга байгууламжийн төлөв байдал: **Шаардлага хангасан.**

Гурав. Дүгнэлтийн хэсэг

✓ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул

□ Барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тул

- Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тул

3.1. Энэ дунд төвөгшилтэй ангиллын зорьтой 9 давхар 1 блок, 10 (арван) автомашины дулаан зогсоолтой, 54 (тавин дөрөв) айлын хүчин чадалтай орон сууцны зориулалттай барилга байгууламж түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

ХЯНАЛТ ШАЛГ
ГАЗАР

Барилга байгууламжийг
орлуулах ко

Энэ барилга байгууламжийн барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

3.2. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

а) барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад ... хоногийн дотор багтаан шилжүүлэх;

б) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

3.3. Ашиглагч байгууллагад:

а) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;

б) барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;

в) барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.

3.4. Комиссын акт 3 хуудас, хуралдааны тэмдэглэл 5 хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт 28 хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1. Дунд төвөгшилтэй ангиллын зорьтой 9 давхар 1 блок, 10 (арван) автомашины дулаан зогсоолтой, 54 (тавин дөрөв) айлын хүчин чадалтай орон сууцны зориулалттай барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан:

Налайх дүүргийн 7 дугаар хороо, Дөлгөөн дөл ХХК-ийн захиалгатай, зорьтой 9 давхар 1 блок, 10 (арван) автомашины дулаан зогсоолтой, 54 (тавин дөрөв) айлын орон сууцны барилга

Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч



(А.Мөнгөн)




Нарийн бичгийн дарга: Дөлгөөн дөл ХХК-ийн гүйцэтгэх захирал



(Ж.Батбаяр)

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын биелэлтийн хуудасны хамт хүчинтэй.



НАЛАЙХ ДҮҮРГИЙН 7 ДУГААР ХОРОО, ДӨЛГӨӨН ДӨЛ
ХХК-ИЙН ЗАХИАЛГАТАЙ, ЗООРЬТОЙ 9 ДАВХАР 1 БЛОК, 10 МАШИНЫ ДУЛААН
ЗОГСООЛТОЙ, 54 АЙЛЫН ОРОН СУУЦНЫ БАРИЛГЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ
КОМИССЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 01 дүгээр сарын 27

Улаанбаатар хот

Налайх дүүргийн 7 дугаар хороо, Дөлгөөн дөл ХХК-ийн захиалгатай, зоорьтой 9 давхар 1 блок, 10 машины дулаан зогсоолтой, 54 айлын орон сууцны барилгыг ашиглалтад оруулах комиссын хуралдаан тус барилгын 1-р давхарт 02 тоотод 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр 10:00 цагт 14 гишүүний бүрэлдэхүүнтэй эхэлж, 13:10 цагт дуусав.

Хуралд:

- | | |
|---|---------------|
| 1. Хяналт шалгалтын газрын
Барилга Байгууламжийн ашиглалт,
бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг
түр орлон гүйцэтгэгч | А.Мөнгөн |
| 2. Хяналт шалгалтын газрын барилгын стандарт,
аюулгүй байдлын хяналтын хэлтэс,
Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч | Ж.Жүгдэрмаа |
| 3. Дэд бүтцийн стандарт хяналтын хэлтсийн
Эрчим хүчний хяналтын Улсын ахлах байцаагч | З.Очирпүрэв |
| 4. Онцгой байдлын ерөнхий газар,
Гал түймэртэй тэмцэх газрын,
Зураг хяналтын тасаг, Дэд хурандаа | М.Батсайхан |
| 5. Барилга хөгжлийн төв
Барилга барилга материалын үйлдвэрлэлийн
хэлтсийн дарга | Д.Батням |
| 6. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах
байгууллага, Монголын тэргэнцэртэй иргэдийн
үндэсний холбоо, хүртээмжийн үнэлгээний ажилтан | Д.Ганбат |
| 7. Үндэсний төв архив, Зураг төслийн
баримтын архивч | Б.Оюунжаргал |
| 8. Цахилгаан түгээх сүлжээ,
Налайх төв Техник үйлчилгээ
хариуцсан ахлах инженер | Б.Алтаншагай |
| 9. Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК
Налайх салбар ерөнхий инженер | М.Лхагвасүрэн |
| 10. Ус сувгийн удирдах газрын
Чандмань Налайх ОНӨААТҮГ
ОСА-1 хэсгийн инженер | Ц.Үйтүмэн |
| 11. Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК
Налайх төвийн Кавель шугамын ахлах инженер | Т.Цэцэгсүрэн |
| 12. Захиалагч байгууллага,
Дөлгөөн дөл ХХК-ийн гүйцэтгэх захирал | Ж.Батбаяр |
| 13. Зураг төсөл зохиогч,
Шувууны хайрга ХХК-ийн гүйцэтгэх захирал | В.Ганбаатар |
| 14. Гүйцэтгэгч байгууллага,
Ус орчин ХХК-ийн инженер | Ц.Мөнхтогтох |

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ГАЗАР
Барилга Байгууламжийг ашиглалтанд
оруулах комисс

ИРЦИЙН БАЙДАЛ

- Мэдэгдэл хүлээн авсан – 14
- Хуралд оролцож үүрэг даалгаврын биелэлтээр санал гаргасан– 14

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Налайх дүүргийн 7 дугаар хороо, Дөлгөөн дөл ХХК-ийн захиалгатай, зоорьтой 9 давхар 1 блок, 10 машины дулаан зогсоолтой, 54 айлын орон сууцны барилгыг ашиглалтад оруулах шаардлага хангасан эсэх талаар хэлэлцэв.

СОНССОН НЬ:

Комисст ажилласан гишүүд барилга байгууламжийн зураг төсөл, баримт бичиг, барилгын ажлын гүйцэтгэлийг хянаж танилцаад дараах саналуудыг гаргав.

Хяналт шалгалтын газрын Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтэс, Барилга техникийн хяналтын улсын ахлах байцаагч **Ж.Жүгдэрмаа**:

- Ажлын зурагны 24-р хуудсанд заагдсан тагтны хашлага гүйцээх Ц2, Ц4 цонхны угсралтын акт хийх, Зургийн авторын дүгнэлт
- Зохиогчийн дүгнэлтийг дүрмийн дагуу бичиж баяжуулан хяналтаар өгсөн үүрэг даалгавар биелсэн эсэхийг тодорхой бичих мөн давхар бүрийн бетон арматурын лабораторийн шинжилгээ төслийн хэмжээнд хүрсэн эсэхийг тус дүгнэлтэнд тусгаж шалгуулах
- Техникийн нөхцөлийн 4,1-р заалтын биелэлт хангах
- Давхаруудын зарим айлуудын эд хогшилийг оруулж угсарч тохижуулсан байгаад захиалагчаас тайлбар ирүүлэх
- Эхний ээлжийн барилга ашиглалтанд орж байгаа бөгөөд үргэлжлэх угсралтын ажлаас А-1 барилгын тусгаарлах талбайн зохион байгуулалтын зураг гүйцэтгэж иргэдийн аюулгүй байдлын хангуулах зураг тайлбар ирүүлж шалгуулах

Комиссын гишүүдийн өгсөн үүрэг даалгаврын биелэлтээр хүлээн авах саналтай.

Хяналт шалгалтын газрын Дэд бүтцийн стандарт хяналтын хэлтсийн Эрчим хүчний хяналтын Улсын ахлах байцаагч **З.Очирпүрэв**:

- Гадна бохир усны худагт шат дулаалгатай таг хийх
- Зоорийн давхарт узелийн өрөөнд гэрэлтүүлэг
- Утаа сорох системд мотор угсарч хэвийн ажиллагааг хангах
- Зоорийн давхарын босоо шугамд зурагт заагдсан даралт тохируулах бланслагч угсрах
- Цэвэр усны босоо шугамд даралт баригч хийх
- Айлуудын босоо шугамд үзлэг хийх ревиз давхар алгасан хийх
- Алчуур хатаагчинд төгсгөлүүдийг хий авагч угсрах
- Айлуудын усны тоолуурт хайрцаг хийх
- Үнэр дарагч фефлентернээс дээш гаргаж өндөрлөх

Гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр хүлээн авах саналтай.

Онцгой байдлын ерөнхий газрын, Гал түймэртэй тэмцэх газрын, Зураг хяналтын тасгийн ахлах байцаагч, дэд хурандаа **М.Батсайхан**:

- Гал унтраах автомат төхөөрөмж спринглерийн системийн төгсгөлд даралт хэмжигч хийж даралттай усаар хангах
- Гал унтраах усны даралтын цэгийг даралттай усаар хангах

- Шатны хонгилийг тусгаарлах галд тэсвэртэй хаалгыг бүх давхарт зураг төслийн дагуу хийх
- Зоорин давхарт буусан шатнуудын өмнө даралттай агаар бүхий гонх хаалтыг зураг төслийн дагуу хийх
- Галын дохиолол мэдээлэгч хүлээн авах станцыг хүн 24 цагаар байрлах өрөө тасалгаанд байрлуулах
- Тусгай зориулалтын авто машин чөлөөтэй орж гарах хөдөлгөөн үйлдэх боломжоор хангах

Татгалзсан.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллага, Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо, хүртээмжийн үнэлгээний ажилтан **Д.Ганбат:**

- Гадна авто зогсоолд хөгжлийн бэрхшээлтэй хүний тэмдэг тэмдэглэгээ хийх
- Хараагүй иргэдэд зориулсан хөтөч замыг стандартын дагуу хийх
- Цахилгаан шатыг монгол хэлтэй болгох, эсвэл давхар бүрт барейл тэмдэгтэй болгох
- Айл болгоны тоот хаалганы хаягийг барейл тоон тэмдэглэгээтэй болгох
- Валконы шилэн хийцлэлд хашлага хамгаалалт хийх
- Фото зургаар баталгаажуулж өгөх

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай.

Үндэсний Төв архив, Зураг төслийн баримтын архивч **Б.Оюунжаргал:**

- Барилгын хувийн хэргийн нийтлэг жагсаалтын дагуу бүрэн бүрдэлтэй өгөх
- Дотоод товъёг стахндартын дагуу хувийн хэрэг ил далд ажлын акт материалын сертификат гарал үүслийн гэрчилгээг хийж өгөх
- БЧХ-ын тэмдэглэл дэвсгэр бүрэн баталгаажуулж бичигдсэн ажлыг нэр бичиж гарчиглах
- Ажлын зурагт нүүр зураг хийж хуудас дугаарлан эх хувь өгөх
- БУ-н ил далд ажлын актын гэрэл зураг ашиглан ажлын дараалалаар дотоод товъёг хийж эх хувиар өгөх

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай.

Барилгын хөгжлийн төв, Барилга барилга материалын үйлдвэрлэлийн хэлтсийн дарга **Д.Батням:**

- Барилгад хэрэглэгдсэн материалын гэрчилгээ тохирлын гэрчилгээ бүрдлийг хангуулах
- Хараагүй иргэдэд зориулсан хөтөч замыг стандартын дагуу хийх
- Барилгын хэмжээнд бүх тагт, болконд хаалт хамгаалалт хийх
- Барилгын тухай хуулийн 5.7.1-д заасны дагуу норм, нормативын төлбөрийг тооцуулж төлөх.

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай.

Ус сувгийн удирдах газрын Чандмань налайх ОНӨААТҮГ ОСА-1 хэсгийн инженер **Ц.Үйтүмэн:**

- Тус барилгын орон сууцны гаднах цэвэр болон бохирын усны худагт орж гарах шат хийх
- Орон сууцны Б1 давхарт байрлах узельд цэвэр усны шугаманд даралт хэмжигч монометр тавих

ХЯНАЛТ ШАЛГА
ГАЗАР

га сайгууламжийг
орлуулах коми

- Халуун хүйтэн ус холилдсон тул шалтгааныг тогтоож янзлах
- Дэд өртөөнд бичлэг пракат байрлуулах

Комиссын гишүүдийн өгсөн үүрэг даалгаврын биелэлтээр хүлээн авах саналтай.

Цахилгаан түгээх сүлжээ, Налайх төв Техник үйлчилгээ хариуцсан ахлах инженер

Б.Алтаншагай:

- Ерөнхий шитэнд байгаа тоолуурыг смарт болгох
- Давхрын шитэнд цоож цүү хийх
- Шитнүүдий газардуулгад бүрэн холбох
- Ерөнхий болон давхарын шитэнд бичлэг плакат ТШТ-н дагуу хийх
- Дэд өртөөнд бичлэг пракат байрлуулах

Комиссын гишүүдийн өгсөн үүрэг даалгаврын биелэлтээр хүлээн авах саналтай.

Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК Налайх төв Техник үйлчилгээ хариуцсан ахлах инженер **М.Лхагвасүрэн:**

- Ашиглалтын заавар өгөх УДДТөвд
- Ариун цэврийн ерөөний алчуур хатаагчинд хий авагч тавих давхарт гаднах цэвэр болон бохир усны худагт орж гарах шат хийх

Комиссын гишүүдийн өгсөн үүрэг даалгаврын биелэлтээр хүлээн авах саналтай

Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК, Налайх төвийн Кавель шугамын ахлах инженер

Б.Цэцэгсүрэн:

- Холбоо дохиоллын кабелиудыг шалгаж хаягжуулах
- Давхрын шитнээс айл хоорондын сүлжээг шалгах төгсгөгч төхөөрөмж суурилуулах
- Домофон системийн гарын авлага бэлдэх, монгол хэл дээр болгох
- Суурилуулах өрөө зориулалтын өрөө гаргах
- Бүх дохиоллуудыг нэг дор болгох хэмжилт хийж хяналт хийж гарын авлага гаргах
- Гадна холбоожуулалт худагт шаттай болгох
- Эвдэрсэн сувагчлалыг сэргээж хэвийн болгох кранштейн бэхлэх
- Кранштейн бэхлэх
- Нэгдсэн мэдээллийн санд оруулах
- Грашийн галын дохиолол хийж шалгах

Комиссын гишүүдийн өгсөн үүрэг даалгаврын биелэлтээр хүлээн авах саналтай.

Зураг төсөл зохиогч, Шувууны хайрга ХХК-ийн гүйцэтгэх захирал **В.Ганбаатар:**

- Комиссын гишүүдийн өгсөн үүрэг даалгаврын биелэлтээр хүлээн авах саналтай.

Барилгын ажлын гүйцэтгэгч, Ус Орчин ХХК-ийн инженер **Ц.Мөнхтогтох:**

- Комиссын гишүүдийн өгсөн үүрэг даалгаврын биелэлтээр хүлээн авах саналтай.

Захиалагч байгууллага, Дөлгөөн дөл ХХК-ийн дэд захирал **Ж.Батбаяр:**

- Комиссын гишүүдийн өгсөн үүрэг даалгаврын биелэлтээр хүлээн авах саналтай

Хяналт шалгалтын газрын Барилга Байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч **А.Мөнгөн:**

- Бүх айлуудын тагтны дээр хязгаарлалтын төмөр хаалт хийх

ЛТЫН

ашиглалтан
сс


- Гадна орчны тохижилт хийх хугацаа өгөх
- Гадна орчны аюулгүй байдлыг хангах зураг үзүүлэх
- БТХ-ийн дагуу чанарын баталгаа ирүүлэх
- Гадна авто зогсоолд тэмдэг тэмдэглэгээ хийх
- Дулаан зогсоолын тоог тодорхойлох
- 2021оны 212 дугаар тогтоолын 8.1-г баримтлах

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Налайх дүүргийн 7 дугаар хороо, Дөлгөөн дөл ХХК-ийн захиалгатай, зорьтой 9 давхар 1 блок, 10 машины дулаан зогсоолтой, 54 айлын орон сууцны барилгыг ашиглалтад оруулах оруулах комиссын гишүүдийн гаргасан үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах, биелэлтээр комиссын дүгнэлт үйлдэх, баталгаажуулах ашиглалтад оруулах.

Танилцсан:

Хяналт шалгалтын газрын
Барилга байгууламжийн ашиглалт,
бүртгэлийн хэлтсийн даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч



(А.Мөнгөн)

Тэмдэглэл хөтөлсөн:
Дөлгөөн Дөл ХХК-ийн Захирал



(Ж.Батбаяр)